



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 08 сарын 04 өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалт, Монгол Улсын Их хурлын 2017 оны “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах тухай” 39 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг дүүргийн хэмжээнд иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх, сургалт, хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хороодод иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах байр, танхим, тоног төхөөрөмжийг бэлтгэх, иргэдийн оролцоог хангах, зохион байгуулалтын арга хэмжээг авч, хэлэлцүүлгээс гарсан иргэдийн саналыг нэгтгэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхийг ажлын хэсэг /Ж.Лхагвасүрэн/- д үүрэг болгосугай.

3. Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахад шаардагдах зардлыг дүүргийн төсвийн зардлаас санхүүжүүлэхийг дүүргийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА  Д.БАТ-ЭРДЭНЭ



1150100127

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 08 дугаар сарын
04-ний өдрийн 55 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСЛИЙГ
ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД ИРГЭД, ОЛОН НИЙТЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ СУРГАЛТ БОЛОН
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, НЭГДСЭН УДИРДЛАГААР
ХАНГАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Ж.Лхагвасүрэн	Засаг даргын Орлогч
Нарийн бичгийн дарга:	Э.Онон	Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн тасгийн дарга
Гишүүд:	Ц.Алтанцацрал	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга
	А.Дамцагдорж	Засаг даргын Тамгын газрын дарга
	Ж.Ганбат	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Удирдлага, зохион байгуулалтын хэлтсийн дарга
	Т.Уламбаяр	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Иргэний оролцоо, олон нийттэй харилцах хэлтсийн дарга
	О.Нямбат	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Б.Лхагваням	Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн Технологи, олон нийттэй харилцах албаны дарга
	Ө.Эрдэнэхүү	Дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн дарга
	Д.Сүрэн	Дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтсийн дарга
	Н.Янжинлхам	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хэвлэл мэдээлэл, мэдээллийн технологи хариуцсан ажилтан

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 08 дугаар сарын
04-ний өдрийн 55 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСЛИЙГ ХОРООДОД ИРГЭД, ОЛОН НИЙТЭЭР
ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ДЭД ХЭСЭГ

Хорооны Иргэдийн Нийтийн Хурлын дарга

Хорооны Засаг дарга

Хорооны Ажлын албаны дарга /зохион байгуулагч/

Хорооны Иргэний танхимын ажилтан

Хорооны Хэсгийн байцаагч